



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Ой, хээрийн түймрээс урьдчилан
сэргийлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.16, 13.1.17 дахь заалт, Улсын онцгой комиссын “Ой, хээрийн гал, түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 2022 оны №01 албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тухайн аймаг, орон нутгийн цаг уурын нөхцөлөөр тогтоосон түймрийн аюулын зэрэглэлд үндэслэн ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах эргүүл шалгалтыг эрчимжүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, ойн зорчих иргэн, байгаль хамгааллын сайн дурын нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагатай хариуцлагын гэрээ байгуулж баталгаа гаргуулан хяналт тавьж ажиллах, түймрийн аюулын үнэлгээ гурав түүнээс дээш зэрэглэлд хүрсэн тохиолдолд тухайн аймаг, сумын нутаг, дэвсгэрийн хэмжээнд явуулж буй ой аж ахуйн арга хэмжээ, иргэдийн аялал зугаалга, амралт, сувиллын зорилгоор ойд зорчих үйл ажиллагааг хориглохыг бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Ой, хээрийн түймрийн цагийн байдлын тухай мэдээлэл авах, түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг шуурхай удирдлагаар хангах үүрэг бүхий жижүүрийг 2022 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр, 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллуулах, түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ойжуулалтын хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлж, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Э.Баттулга)-д тус тус зөвшөөрсүгэй.

4. Түймрийн жижүүрийг ой, хээрийн түймрийн голомт, тархалтын зураг бусад шуурхай мэдээллээр хангах, шаардлагатай тохиолдолд ажлын бус цаг, амралтын өдрүүдэд сансрын хиймэл дагуулын түймрийн тархалтын зургийг шуурхай боловсруулж, Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хурээлэнгийн сайт


(www.icc.mn)-д байрлуулан, мэдээллээр хангаж ажиллахыг Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн (Г.Сарантуяа)-д үүрэг болгосугай.

5.Хавар, намрын хуурайшлын зэргийг долоо хоног бүрээр тодорхойлж, олон нийтийн телевиз, радио, мэдээллийн хэрэгслээр гал, түймрийн эрсдэл өндөртэй аймаг, сумдыг тогтмол мэдээлж, мэдээлэл солилцох холбооны хэрэгслээр хангаж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (С.Энхтүвшин)-т үүрэг болгосугай.

6.Ой, хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эргүүл шалгалтыг эрчимжүүлэх, түймэр унтраах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, зардлыг шийдвэрлэж ажиллах талаар Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаадаад тодорхой үүрэг, даалгавар өгч, хяналт тавьж ажиллахыг Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар (Д.Батмөнх)-т үүрэг болгосугай.

7.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, сэргэмжлүүлгийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, гарсан түймрийг шуурхай илрүүлэх, иргэдийн амь нас, эд хөрөнгө, байгалийн нөөц баялгийг түймрээс хамгаалах ажлыг оновчтой зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг эрчимжүүлэхийг Ойн бодлого, зохицуулалтын газар (Б.Оюунсанаа), Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар (А.Энхбат), Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах алба (Ц.Үүрцайх)-д тус тус үүрэг болгосугай.

8.Түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, орон нутагт түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын техникийн, мэргэжлийн бэлэн байдлыг хангуулах ажлуудыг эрх бүхий байгууллагуудтай хамтран зохион байгуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд (Г.Түвдэндорж), Ойн бодлого, зохицуулалтын газар (Б.Оюунсанаа)-т тус тус даалгасугай.



Улсын онцгой комиссын албан даалгаврын дагуу ой, хээрийн түймрээс урьдчилсан сэргийлэх, хамгаалах талаар 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөө

Байгаль орчин, аялал жуулчлалы сайдвны
2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн
А/Ч дугаар тушаалын хавсралт

№ оны 01 дугаар албан даалгаврын заалт	Улсын онцгой комиссын 2022 Авах арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэх газар, нэгж	Биелэлт
3.1.Ой, хээрийн гап түймэр гарах эрсдэл өндөртэй аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороодод Гамшигаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд, Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар тогтолын хэрэгжилтийг хангулан техник бараж хэрэгслийн нөөцийг бурдуулж, бэлтгэл, бэлэн байдлыг дээшилүүлэн ажиллахыг,	1.ОХУ, БНХАУ-тай хиллэх улсын хилийн бусэд хил дамнан гарах ой, хээрийн түймрийн мэдээллийг хөрш орнуудтай солилцох, зурган болон бусад мэдээг боловсруулж холбогдох байгууллагуудад шуурхай хүргж ажиллах 2.Түймрийн эрсдэлийн бусэд байрлах Улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа, Сум дундын ойн ангиудыг түймрээс урьдчилсан сэргийлэх, хамгаалах зориулалтын зарим бараж, хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах 3.Ойн неөц, баялагт учруулсан түймрийн хохирлыг тогтоох, тооцоход мэргэжил-аргazийн удирдлагаар хангаж ажиллах.	1.ОХУ, БНХАУ-тай хиллэх улсын хилийн бусэд хил дамнан гарах ой, хээрийн түймрийн мэдээллийг хөрш орнуудтай солилцох, зурган болон бусад мэдээг боловсруулж холбогдох байгууллагуудад шуурхай хүргж ажиллах 2.Түймрийн эрсдэлийн бусэд байрлах Улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа, Сум дундын ойн ангиудыг түймрээс урьдчилсан сэргийлэх, хамгаалах зориулалтын зарим бараж, хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах 3.Ойн неөц, баялагт учруулсан түймрийн хохирлыг тогтоох, тооцоход мэргэжил-аргazийн удирдлагаар хангаж ажиллах.	-Байгаль орчин, аялал жуулчлалын жуулчлалын яам, -Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар -Онцгой байдлын өрөнхий газар -Хил хамгаалах ерөнхий газар	2,3,4-р улирал

3.2.Ойн тухай хуулийн гуравдугаар бүлгийн 13 дугаар зүйлийн 13.1.16-д заасны дагуу Цаг уур, орчны судалгаа, Мэдээллийн хурээлэнтийн сансрын хиймэл дагуулын мэдээлээр авсан цаг агаарын болон ой, хээрийн гал түймрийн голомт, тархалтын зураг, хураайшилтын мэдээг тухай бурд (баяр, амралтын өдргүйдээ) шуурхай боловсруулж, Онцгой байдлын байгууллагаад хургүүлэхийг,	2.	1.Түймрийн эрсдэлтэй бус, нутгийн хувь, намарын цаг уурын нэхцэлээр тодорхойлсон хураайшилын зэргийг долоо хоног бүрээр гаргаж, холбогдох байгууллагуудад хургүүлэх 2.Түймрийн аюулын зэрэг болон эрсдэл ондертэй аймаг, сумдыг олон нийтийн телевиз, радио, Мэдээллийн хэрэгслээр мэдээлэх 3.Сансрын хиймэл дагуулын мэдээг ашиглан ой, хээрийн түймрийн тархалт, голомтыг тухай бур тодорхойлж, Түймрийн цагийн байдлын тухай мэдээллийг Онцгой байдлын болон холбогдох байгууллагуудад хургүүлэх	1.Түймрийн эрсдэлтэй бус, нутгийн хувь, намарын цаг уурын нэхцэлээр тодорхойлсон хураайшилын зэргийг долоо хоног бүрээр гаргаж, холбогдох байгууллагуудад хургүүлэх 2.Түймрийн аюулын зэрэг болон эрсдэл ондертэй аймаг, сумдыг олон нийтийн телевиз, радио, Мэдээллийн хэрэгслээр мэдээлэх 3.Сансрын хиймэл дагуулын мэдээг ашиглан ой, хээрийн түймрийн тархалт, голомтыг тухай бур тодорхойлж, Түймрийн цагийн байдлын тухай мэдээллийг Онцгой байдлын болон холбогдох байгууллагуудад хургүүлэх	2,3,4-р упирал	-Байгаль орчин, аялал жуулчлалын яам, -Цаг уур, орчны шинжилгээний газар -Ус, цаг уур, орчны судалгаа, Мэдээллийн хурээлэн -Онцгой байдлын ерөнхий газар
3.3.Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.30-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал Түймрийн аюултай чед ой, хээрийн гап түймрээс сээрэмжтүүлэх, орон нутагт эргүүл, харуул ажилтуулах болон энэ ажилд бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захирагааны байгууллагатай хамтран ажиллахыг,	3.	1.Ой, хээрийн түймрийн эрсдэл бүхий аймаг, сумдад түймрийн аюултай улирлын туршид эргүүл, харуул гаргах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах 2.Улсын тусгай хамгаалалттай газруудын ойт түймрээс хамгаалах сургалт, сурталчилгаа явуулах, түймрийн эрсдэлийн бусэд иргэдийн зорчих хөдөлгөөнийг бүртгэх, хяналтын худас бэлтгэж, ашиглах, зарим бус нутгийг тэмдэгжүүлэх, самбар байрлуулах ажлыг зохион байгуулах	Жилийн турш	-Байгаль орчин, аялал жуулчлалын яам, -Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар -Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, ойн анги	
		3.Түймрийн цагийн байдлын тухай мэдээллийг холбогдох байгууллага, иргэдэд мэдээлэх шуурхай зохицуулах жижүүрийг 2021 оны 03 дугаар сарын 20-оос 6 дугаар сарын 10, 09			

		Дүгээр сарын 20-оос 11 дүгээр сарын 10-ны хооронд яамны дэргэд ажиллуулах.	-Цагдаагийн байгууллага -Мэргэжлийн хяналтын байгууллага
3.4. Монгол Улсын 153	1.Хяналтын нислэгийг нэг удаа үйлдэх зардлыг ойжуулалт хөтөлбөрт тусгаж, тухайн түймрийн дугаар зарлигийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.4-т заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй бус нутагт гол түймрээс урьдчилан сэргийлэх үйлдэх зардлыг тусгаж, сэргийлэх хяналтын нислэг үйлдэх зардлыг тусгаж, зэвсэгт хүчиний байгууллагатай хамтран нислэг үйлдэхийг,	1.Ойжуулалт хөтөлбөрт тусгаж, тухайн түймрийн байдалтай уялдуулан боловсруулж нислэгийн багт хургуулэх 2.Ойг түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хамжээнд шаардагдах зардлын төсвийг төлөвлөж, батгуулах.	-Байгаль орчин, аялал жуулчлалын яам, -Цаг уур, орчны шинжилгээний газар -Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
3.5. Монгол Улсын 153	1.Ой, хээрийн түймрийг илрүүлах, түймэр гарсан тохиолдолд иргэдийн амь нас, байгалийн нөөц, дугаар зарлигийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2.15-Д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, аюул тулгарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зохион байгуулалтын талаар олон идэвхжүүлж, мэргэжил, аргазүйн удирдлагагар нийтийг мэдээлэл, заавар, зөвлөмжээр хангах, навтрүүлэг бэлтгэх, сургалт сургалчилгаа зохион байгуулах,	1.Баялагийн хамгаалах талаар мэдээлэл-сургалчилгаа байгууллагатай хамтран ажиллах 2.Түймрийн эрсдэлийн бусад байрлах аймгуудын Засаг даргын дэргэдэх түймрээс хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, мэргэжил, аргазүйн удирдлагагар хангаж ажиллах.	-Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар -Онцгой байдлын байгууллага -Цагдаагийн байгууллага -Мэргэжлийн хяналтын байгууллага

	3.6. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардлагдах төсөв, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, сумны нөөцийг бурдуулэх, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалаалт, хамгаалалтад хяналт тавих, шаардлагатай үед ашиглахыг, хангаж ажиллах	6.	1."MODIS" хиймэл дагуулын мэдээ, зургийг шуурхай гаргаж холбогдох байгууллагуудад хүргэж үйлчлэх, шаардлагатай тохиолдолд үүлэнд зориудаар нөлөөлөх ажлыг зохион байгуулах 2. Сансырын хиймэл дагуулын түймрийн тархалтын зургийг шуурхай болсовруулж, Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хэрээлэнгийн сайт (www.icc.mn)-д байрлуулсан, мэдээллээр хангаж ажиллах	2, 3-р улирал	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, -Цаг уур, орчны шинжилгээний газар -Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
3.7. Ойн тухай хуулийн дагуу хавар, намрын хуурайшилтийн улиралд ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалт баяягийг ашиглах, аялал зугаалгаар явах үйл ажиллагааг хугацаагаар.	7.	1. Ой, хэзрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлэх тухай тушаал, тепөвлөгөө боловсруулж, улсын хэмжээнд хэрэгжилтийг хангуулан ажиллах 2. Ойн тухай хууль, тогтоомж болон Засгийн газрын 106-р тогтоопыг сурталчлах ажлыг орон нутагт зохион байгуулах	Жилийн түрш	-Байгаль орчин, аялал жуулчлалын яам, -Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар -Цагдаагийн ерөнхий газар	
3.8. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх, хамгаалалтын широон болон ойн зурвасыг	8.	1. 2022 онд 32,0 мянган га ойн талбайд арчилгаа, цэвэрлэгээ хийх 2. Ойн нөхөн сэргээлтийг 6,0 мянган га талбайд хийх	Жилийн түрш	-Байгаль орчин, аялал жуулчлалын яам,	

	сэргээх, шинээр нэмж хийх, усан сан, цөөрөм байгуулах ажлыг зохион байгуулахыг,	3.Хил дамнасан түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор 10-20 м өргөн, 187,6 км ут зурvas шинээр, 782.2 км ут зурvasыг сэргээх ажлыг Улсын хилийн дагуу Хил хамгаалах ерөнхий газартай гэрээ байгуулж, хамтран хэрэгжүүлэх.	-Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
9.	3.9.Ойн сан бүхий газарт гол түймэртэй тэмцэх, түнээс сэргийлэх талаар Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлэгтүй иргэн, хуулийн зааснаар арга хэмжээ авч, улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч нарын ажлыг эрчимжүүлж ажиллахыг,	1.Түймрийн аюулын үнэлгээ гурав түүнээс дээш зэрэглэлд хүрсн тохиолдолд тухайн аймаг, сумын нутаг, давсгэрийн хэмжэнд явуулж буй ой аж ахуйн арга хэмжээ, иргэдийн аялал зугаалга, амрапт, сувиллын зорилгоор ойд зорчих Үйл ажиллагааг хориглохыг бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга наарт Уурэгжүүлэх 2.Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албатай хамтран ажиллах	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Түймрийн аюултاي улирлын туршид -Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар -Цагдаагийн ерөнхий газар